ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДГА-2026/11/НА-СТА-ТТЗ**


Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунбаатар

Цахим хаяг:ariunbaatarb@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2026 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ . 5
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .......... 9
5.1 Залруулга .......... 9
5.2 Албан шаардлага .......... 9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .......... 10

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ХХС | Хоршоо хөгжүүлэх сан |
| ННС | Нөхөн сэргээлтийн сан |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ҮАЗ | Үйл ажиллагааны зардал |

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.03.25 № 1-6/360

танай____________-ны №______________-т

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГА Ч.ТҮВШИНТӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сайншанд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сумын Засаг даргын 2024.05.10-ны өдрийн А/144 дүгээр захирамжаар "Хадлан хураах боох, тэжээлийн ургамал тарих тоног төхөөрөмж худалдан авах" ажлыг сумын ОНХС-ын хөрөнгөөр Алянстрейд ХХК-иар 136,289,000 төгрөгөөр гүйцэтгүүлэн 2024.07.03-ны өдрийн СКА-12/2024 дугаар тоног төхөөрөмж хүлээн авах комиссын актаар хүлээж авсан бөгөөд тухайн хөрөнгийг ""Тахилт агро"" ХХК-нд түрээслэн /2024.07.18-ны өдрийн 01 дүгээр эд хөрөнгө ашиглах гэрээ/ түрээсийн төлбөрт 4 жилийн хугацаанд хуваарийн дагуу нийт 15000 боодол өвс тэжээл авахаар гэрээнд тусгасан боловч хөрөнгө ашиглагч компани хуваарийн дагуу гэрээний төлбөр болох өвс тэжээлээ нийлүүлээгүй 2025 онд 3500 боодол өвс, тэжээл хүлээлгэн өгөх байтал 1229 боодол өвс хүлээлгэн өгч 1771 боодол өвс, тэжээл дутуу авсан ба гэрээний 4.4-т "ашиглаж байгаа эд хөрөнгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд хийгээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданги ногдуулна" заасан байхад тодорхой арга хэмжээ аваагүй зөрчилд 11.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

**Аудитын гол асуудал**

Сумын Засаг даргын 2025.01.29-ний өдрийн А/15 дугаар захирамжаар

442505333

Тайвань улсын Тайпай хотод зохион байгуулагдах "Ухаалаг хотуудын дээд хэмжээний уулзалт-Экспо 2025" арга хэмжээнд оролцох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн онгоцны тийзийн зардал болох 8.9 сая төгрөгийг "Эрүүл хот хөтөлбөрийг хэрэгжүүлэх" ТББ- руу шилжүүлсэн. Гэвч тухайн арга хэмжээнд оролцох боломжгүйн улмаас тийзийн 8.2 сая төгрөгийг буцааж, 0.7 сая төгрөгийг шимтгэлд суутгаж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "*үр ашигтай байх*", 4.1.6 "*сахилга баттай байх*", 4.1.7 "*бодитой байх*" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Тус байгууллага нь 2024.07.18-ны өдрийн 01 дугаартай эд хөрөнгө ашиглах гэрээг 4 жилийн хугацаатай Тахилт агро ХХК-тай байгуулан түрээсийн төлбөрт нийт 15,000 боодол өвс тэжээлийг хуваарийн дагуу авахаар халилцан тохиролцсон боловч 2024 оны гэрээний төлбөрийг 2025 онд барагдуулсан, 2025 оны гэрээний төлбөрийг дутуу /2,271 боодол өвс, тэжээл/ төлсөн байхад гэрээнд заагдсан чиг үүргийг хангуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Иргэний тухай хуулийн 318 дугаар зүйлийн 318.1 "*Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ*", Сайншанд сумын Засаг даргын Тамгын газартай байгуулсан 2024.07.18-ны өдрийн 01 дугаартай эд хөрөнгө ашиглах гэрээний 9 "*Гэрээг хугацаанаас өмнө цуцлах үндэслэл*", 9.1 "*Ашиглагч нь ашиглаж байгаа эд хөрөнгийн төлбөрөө 2 сар хүртэл хугацаагаар хожимдуулан төлөх, гэрээ болон хуульд заасан нөхцөл бүрдэх*" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

*АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | 1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,863,660.76 | 1,114,292.47 |
| 31 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,034,904.49 | 806,257.75 |
| 33 | 1.1.3 АВЛАГА | 114,431.66 | 198,220.32 |
| 34 | 1.1.4 УРЬДЧИЛГАА | 580,963.69 | - |
| 34600 | 1.1.4.06 Урьдчилж гарсан зардал | 580,963.69 | - |
| 35 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 133,360.92 | 109,814.40 |
| 2 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 6,283,198.51 | 8,013,035.05 |
| 39 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 6,283,198.51 | 8,013,035.05 |
| 39200 | 1.2.2.02 Биет хөрөнгө | 6,135,834.51 | 7,865,791.05 |
| 39300 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 147,364.00 | 147,244.00 |
| **3** | **1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **8,146,859.27** | **9,127,327.52** |
| 4 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | 25,851.82 | 84,993.22 |
| 41 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 25,851.82 | 84,993.22 |
| 41300 | 2.1.1.03 Өглөг | 25,851.82 | 84,993.22 |
| 5 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 8,121,007.44 | 9,042,334.29 |
| 51 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | 8,121,007.44 | 9,042,334.29 |
| 51100 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | 1,518,273.84 | 1,518,273.84 |
| 511002 | 2.2.1.01.02 Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 1,518,273.84 | 1,518,273.84 |
| 51200 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | 6,435,769.99 | 7,357,096.84 |
| 51300 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 166,963.62 | 166,963.62 |
| **6** | **2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **8,146,859.27** | **9,127,327.52** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 10,546,993.55 | 11,615,898.01 |
| 11 | 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 4,585,429.59 | 5,325,925.23 |
| 110 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | 4,267,042.07 | 4,870,184.46 |
| 1100 | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | 4,267,042.07 | 4,870,184.46 |
| 113 | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 75,655.85 | 13,115.80 |
| 118 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 242,731.66 | 442,624.97 |
| 12 | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,070,908.31 | 6,289,972.77 |
| 13 | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,890,655.65 | - |
| II | 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 7,508,840.46 | 10,546,446.15 |
| 21 | 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 7,508,840.46 | 10,546,446.15 |
| 210 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,797,965.58 | 3,181,667.68 |
| 2101 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 942,038.90 | 1,113,734.73 |
| 2102 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 118,443.37 | 136,456.18 |
| 2103 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 488,007.79 | 550,276.44 |
| 2104 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 391,456.58 | 102,577.70 |
| 2105 | 1.1.2.01.1.05 Нормативт зардал | 67,171.32 | 43,597.28 |
| 2106 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 44,356.87 | 25,502.35 |
| 2107 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 23,811.80 | 11,050.00 |
| 2108 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 760,235.00 | 361,859.58 |
| 2109 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 962,443.96 | 836,613.42 |
| 213 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,710,874.88 | 7,364,778.47 |
| 2131 | 1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг | 3,692,690.13 | 7,351,778.47 |
| 2132 | 1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг | 18,184.75 | 13,000.00 |
| III | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 3,038,153.09 | 1,069,451.85 |
| V | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,415.51 | 148,125.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 225001 | 1.2.2.01 Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 1,337.01 | - |
| 225010 | 1.2.2.10 Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 78.50 | 148,125.00 |
| VII | 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | (1,415.51) | (148,125.00) |
| VI | 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 3,036,737.58 | 921,326.85 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,084,269.86 | - | 5,084,269.86 |
| 2 | 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 83.16 | - | 83.16 |
| 3 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,084,353.02 | - | 5,084,353.02 |
| 4 | 1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (83.16) | - | (83.16) |
| 9 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 3,036,737.58 | - | 3,036,737.58 |
| 10 | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 8,121,007.44 | - | 8,121,007.44 |
| 11 | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 8,121,007.44 | - | 8,121,007.44 |
| 13 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 8,121,007.44 | - | 8,121,007.44 |
| 19 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 921,326.85 | - | 921,326.85 |
| 20 | 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 9,042,334.29 | - | 9,042,334.29 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 8,134,984.20 | 9,244,627.52 |
| 11 | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 4,585,429.59 | 5,325,925.23 |
| 110 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 4,267,042.07 | 4,870,184.46 |
| 1100 | 1.1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | 4,267,042.07 | 4,870,184.46 |
| 113 | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 75,655.85 | 13,115.80 |
| 118 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 242,731.66 | 442,624.97 |
| 1180 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 56,468.49 | 84,880.88 |
| 1181 | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 110,730.38 | 237,792.09 |
| 1182 | 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 75,532.80 | 119,952.00 |
| 12 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 563,569.14 | 3,918,702.28 |
| 120 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 563,569.14 | 2,632,433.79 |
| 120003 | 1.1.1.1.04.1.03 Торгуулийн орлого | 75,734.69 | 2,501,343.86 |
| 120004 | 1.1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого | 303,481.15 | 86,715.13 |
| 120009 | 1.1.1.1.04.1.09 Бусад орлого | 184,353.30 | 44,374.80 |
| 122 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | - | 830,475.57 |
| 1221 | 1.1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/ | - | 830,475.57 |
| 12211 | 1.1.1.1.04.3.01.01 Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 490,493.59 |
| 12213 | 1.1.1.1.04.3.01.03 Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 339,981.98 |
| 122134 | 1.1.1.1.04.3.01.03.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 29,864.54 |
| 122135 | 1.1.1.1.04.3.01.03.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 310,117.44 |

| | | | |
|---|---|---|---|
| 123 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 455,792.93 |
| 123002 | 1.1.1.1.04.4.02 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого \УТ-ОН\ | - | 455,792.93 |
| 13 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,985,985.47 | - |
| II | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 7,337,117.56 | 9,437,894.26 |
| 21 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 7,337,117.56 | 9,437,894.26 |
| 210 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,056,806.54 | 2,654,079.47 |
| 2101 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 970,925.19 | 1,131,011.93 |
| 2102 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 123,508.70 | 129,361.43 |
| 2103 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 491,997.64 | 548,678.52 |
| 2104 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 83,172.28 | 50,685.12 |
| 2105 | 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | 350.00 | - |
| 2106 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 42,227.37 | 30,492.35 |
| 2107 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 22,461.80 | 10,890.00 |
| 2108 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,077,795.51 | 475,675.66 |
| 2109 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 244,368.05 | 277,284.47 |
| 213 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,280,311.02 | 6,783,814.79 |
| 2131 | 1.1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг | 4,271,988.27 | 6,770,814.79 |
| 213113 | 1.1.1.2.01.4.01.01.3 Аймаг, сум хоорондын шилжүүлгийн зардал | - | 5,684,682.20 |
| 213101 | 1.1.1.2.01.4.01.01.9 Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг | 4,271,988.27 | 1,086,132.59 |
| 2132 | 1.1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг | 8,322.75 | 13,000.00 |
| 213209 | 1.1.1.2.01.4.02.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,322.75 | 13,000.00 |
| III | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 797,866.63 | (193,266.74) |
| V | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 119,143.90 | 35,380.00 |
| 22 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 119,143.90 | 35,380.00 |
| 2200 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 119,143.90 | 35,380.00 |
| VI | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (119,143.90) | (35,380.00) |
| VIII | 1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 678,722.73 | (228,646.74) |
| 101 | 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 356,181.76 | 1,034,904.49 |
| 20 | 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,034,904.49 | 806,257.75 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | 3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 16,945,422.70 | 16,648,190.63 |
| 11 | 3.1.01.1.1 Татварын орлого | 5,670,008.10 | 5,325,925.23 |
| 110 | 3.1.01.1.1.1 Орлогын албан татвар | 5,121,196.80 | 4,870,184.46 |
| 113 | 3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар | 19,532.90 | 13,115.80 |
| 118 | 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 529,278.40 | 442,624.97 |
| 1180 | 3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 129,720.00 | 84,880.88 |
| 1181 | 3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр | 279,606.40 | 237,792.09 |
| 1182 | 3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 119,952.00 | 119,952.00 |
| 12 | 3.1.01.1.2 Татварын бус орлого | 2,357,695.20 | 11,322,265.40 |
| 120 | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 2,357,695.20 | 2,602,433.79 |
| 122 | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | 8,446,740.00 | 8,264,038.68 |

| | | | |
|---|---|---|---|
| 123 | 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 470,979.40 | 455,792.93 |
| II | 3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 9,779,693.90 | 16,909,969.73 |
| 21 | 3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 9,779,693.90 | 16,909,969.73 |
| 210 | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,958,669.00 | 2,365,609.85 |
| 2101 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,122,235.50 | 1,131,011.93 |
| 2102 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 140,279.40 | 129,361.43 |
| 2103 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 569,812.60 | 548,678.52 |
| 2104 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 64,523.60 | 44,859.56 |
| 2106 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 82,525.00 | 34,497.35 |
| 2107 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 14,350.00 | 10,260.00 |
| 2108 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 924,542.90 | 440,258.49 |
| 2109 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 40,400.00 | 26,682.58 |
| 213 | 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,821,024.90 | 14,544,359.88 |
| 2131 | 3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг | 6,813,124.90 | 14,544,359.88 |
| 2132 | 3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 7,900.00 | - |
| 8 | 3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 7,165,728.80 | (261,779.10) |
| 7 | 3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (7,165,728.80) | 261,779.10 |
| 4 | 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 1,029,170.39 |
| 5 | 5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 767,391.29 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Тайлант он |
|---|---|---|
| 1 | 1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 339,981.98 |
| 12 | 1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 339,981.98 |
| 122 | 1.1.1.1.1.1 Тусламжийн орлого | 339,981.98 |
| 1221 | 1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/ | 339,981.98 |
| 12213 | 1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого | 339,981.98 |
| 350014 | 1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,864.54 |
| 350015 | 1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 310,117.44 |
| II | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 77,247.73 |
| 21 | 1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 77,247.73 |
| 210 | 1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 74,247.73 |
| 2104 | 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 5,825.56 |
| 210402 | 1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун | 5,825.56 |
| 2106 | 1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 5,495.00 |
| 210604 | 1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар | 5,495.00 |
| 2107 | 1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 630.00 |
| 210702 | 1.1.1.2.1.1.7.2 Дотоод албан томилолт | 630.00 |
| 2108 | 1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 61,297.17 |
| 210801 | 1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 61,297.17 |
| 2109 | 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000.00 |
| 210901 | 1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000.00 |
| 213 | 1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,000.00 |
| 2132 | 1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 3,000.00 |
| 213209 | 1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000.00 |
| 4 | 1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 262,734.25 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сан түүврээр хамрагдаж байна.

Нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулан шалгасан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 1 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 77,628.6 сая төгрөгийн 20 алдаа, зөрчил илрүүлснээс 77,358.4 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй 270.2 сая төгрөгийн 14 зөрчилд 10 албан шаардлага, 3 зөвлөмж, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 1,423.8 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0 төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүллээ.

### 5.1 Залруулга

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогын төлөвлөгөөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан төлөвлөгөөнөөс 1,423.8 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.

### 5.2 Албан шаардлага

*Илрүүлэлт:* Сумын татварын болон татварын бус 6 орлого 354.9 сая төгрөгөөр тасарч, 7 орлого 264.7 сая төгрөгөөр давж нийт сумын орлогын гүйцэтгэл 90.5 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “*бүх шатны төсвийн захиргач нь хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх үүргийг хүлээнэ*” гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад

талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТТЗ нэгтгэл тайлан | 1 | 1,423.8 | | | 1 | 1,423.8 | 1 | 1,423.8 | - | - | - | - |
| ИТХ | 1 | 309.8 | 1 | 309.8 | - | - | 1 | 309.8 | - | - | - | - |
| ЗДТГ | 2 | 5,009.8 | | | 2 | 5,009.8 | 2 | 5,009.8 | - | - | - | - |
| ОНХС | 2 | 1,038.0 | 2 | 1,038.0 | - | - | 2 | 1,038.0 | - | - | - | - |
| ХХС | 1 | 0.8 | 1 | 0.8 | - | - | 1 | 0.8 | - | - | - | - |
| НСС | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **7** | **7,782.2** | **4** | **1,348.6** | **3** | **6,433.6** | **7** | **7,782.2** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ТТЗ нэгтгэл тайлан | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| ИТХ | 3 | 26.0 | - | - | 2 | 25.7 | 1 | 0.3 | - | - | - | - |
| ЗДТГ | 4 | 107.4 | - | - | 2 | 64.0 | 1 | 43.4 | 1 | - | - | - |
| ОНХС | - | - | | | - | - | - | - | | | | |
| ХХС | 1 | 54.2 | - | - | 1 | 54.2 | - | - | - | - | - | - |
| НСС | - | - | - | - | - | - | - | - | | | | |
| **Дүн** | **9** | **187.6** | **-** | **-** | **6** | **143.9** | **2** | **43.7** | **1** | | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ИТХ | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| ЗДТГ | 1 | - | | - | 1 | - | - | - |
| **Дүн** | **2** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **1** | **-** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| ИТХ | 1 | 5.2 | - | - | 1 | 5.2 | **-** | **-** |
| ЗДТГ | 3 | 77.4 | - | - | 3 | 77.4 | **-** | **-** |
| **Нийт дүн** | **4** | **82.6** | **-** | **-** | **4** | **82.6** | **-** | **-** |